

ХАРХОРИН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА



### ХАРХОРИН СУМЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Өвөрхангай аймгийн Харخورин сумын 2-р багийн нутаг, Амралт зугаалгын талбайн ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл болон холбогдох стандарт, нормын дагуу хийх ба дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

#### 1. Ажилд тавигдах ерөнхий шаардлага:

Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг чанд мөрдөж ажиллана. Барилгын ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаяна.

Гүйцэтгэгч нь ашиглагч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.

Барилга угсралтын ажлыг батлагдсан зураг, төслийн дагуу гүйцэтгэж, ажлыг үе шат бүрт захиалагчид үзүүлж, фото зургаар баталгаажуулж, акт үйлдсэний дараа дараагийн ажил үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.

Ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын талбай дээр их хэмжээгээр татахаасаа өмнө дээжийг захиалагчид үзүүлж, зөвшилцөх зарчим баримталж ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй, буруу буюу чанаргүй материал авчирч, ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлаа гүйцэтгэгч хариуцна.

#### 2. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага:

Явган замын ажилд хэрэглэгдэх материал нь "Явган зам, талбайн хавтан техникийн шаардлага" MNS 4699:99 стандартад нийцсэн байна. Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байна.

Материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтэт технологи, хандлагыг бүрэн хангасан байна.

Тохижилтын ажилд хэрэглэх элс, хайрга, цемент зэрэг түүхий эд материалууд нь итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан, хүлээн зөвшөөрөгдсөн түүхий эд материалууд байна. Орон нутгаас элс хайрга зэрэг барилгын материал авч хэрэглэх тохиолдолд түгээмэл тархацтай ашигт малтмалын гэрээ хийсэн байна.

Дараах түүхий эд материал нь чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх ба итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн чанарын шинжилгээний бичигтэй байх

Үүнд: Цемент, элс, хайрга, бордюр, явган замын хавтан, чулуун хавтан, бусад материалууд Шаардлага хангасан тухай шинжилгээний бичиггүй түүхий эд, материалыг тохижилтын ажилд хэрэглүүлэхгүйболно.

#### 3. Сандал, хогийн саванд тавигдах шаардлага:

Сандал нь сайн чанарын хатаасан модоор хийгдсэн, төмөр хүрээтэй, түшлэгтэй, гадна талбайн зориулалттай, нар салхинд тэсвэртэй өнгөлгөөний лакаар будсан, өнгө үзэмж сайтай байна. Бетон болон газарт бэхлэх зориулалтын бэхэлгээтэй байна.

Хогийн сав нь сайн чанарын төмрөөр хийгдсэн, хогийг ангилан ялгах боломжтой, гадна талбайн зориулалттай, хогийг гаргаж авахад хялбар давхар тусгаарлагч савтай байх.

#### 4. Гэрэлтүүлгийн ажилд тавигдах шаардлага:

Талбайд суурилуулах гэрэлтүүлгийн цахилгаан хангамжийн ажлыг ЭБЦТС ТӨХК-ийн Хархорин салбарын олгосон техникийн нөхцлийн дагуу, холбогдох норм стандартыг баримтлан гүйцэтгэнэ. Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн  $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна. Талбайд үйлдвэрт угсарсан 3.5-4 метрийн өндөртэй гэрэлтүүлгийг суурилуулна.

Кабелийн сүвэгчилгээний шуудууны гүн 30-40 см, шонгийн газарт суулгахдаа суурийг цутгаж, зориулалтын анкер боолтоор боож бэхэлнэ. Гэрэлтүүлгийн өнгө үзэмж, загвар хийцийг, урьдчилан фото зураг, гарал үүслийн гэрчилгээнд үндэслэн захиалагчтай зөвшилцөж нийлүүлнэ. Гэрэлтүүлгийн шон хоорондын зайг гэрлийн тусгал жигд тусахаар талбай дээрх зай хэмжээнд тохируулан байршуулна. Гэрэлтүүлэгч нь 60Вт-с доошгүй хүчин чадалтай хурц гэрэлтүүлэмж бүхий диодтой цагаан өнгийн лед гэрэлтүүлэгч байна. Автоматаар удирдах боломжтой ба гэрэлтүүлгийн удирдлагын самбарт асааж унтраах цагийн тохируулгатай байна. Цахилгааны тоолуур нь өдөр, шөнийн цагийн тарифтай 3 фазын баталгаажуулсан тоолуур байна.

Ажлыг "Хот тосгон ба, суурин газрын гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх" БД 30-102-11, "Цахилгаан техникийн ажил" БНБД 3.05.06-90, "Цахилгаан байгууламжийн дүрэм" БД 43-101-03 барилгын норм, цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, цахилгааны тоног төхөөрөмж ашиглалтын үед мөрдөх дүрмүүдийн дагуу хийж гүйцэтгэх ба ажлын зураг төсвийг баримтлан гүйцэтгэх шаардлагатай. Ажил хийгдсэний дараа далдлагдсан ажлын гүйцэтгэлийн схем зургийг гаргаж захиалагч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгнө.

#### 5. Явган зам талбайн ажил:

Явган замын ажлыг "Явган зам, талбайн хавтан техникийн шаардлага" MNS 4699:99, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох гарах гарцыг MNS 5682:2006-г тус тус мөрдөх Явган зам хийх талбайн ургамалын хөрсийг хуулж тэгшлэх, элсэн дэвсгэр үеийг зориулалтын нягтруулагчаар нягтруулна. Үүний дараа 10см зузаан элсэн дэвсгэр дэвсэнэ.

Явган зам болон авто машины зогсоолын талбайн боридюрийг заасан хэмжээгээр авч хэрэглэх ба ажлын талбайд бордюрыг цутгаж хэрэглэхгүй байх. Явган замын хавтангийн сонголтыг захиалагчтай тохиролцон зурагт заасны дагуу хээний байгуулалтаар хийж гүйцэтгэнэ. Явган замын өнгөт хавтангийн үйлдвэрлэгчийн катологи болон хавтангийн дээжийг ирүүлж, захиалагчтай зөвшилцөх Явган замын усны уналтыг газар дээр нь тохируулж, үерийн усанд автахгүй байх боломжийг тооцоолон гүйцэтгэнэ.

#### 6. Авто зам, авто зогсоолын ажил

Ажил гүйцэтгэхдээ дараах норм дүрэм, стандартыг дагаж мөрдөнө.

- Авто зам барих норм /БНБД32-02-00/
- Авто зогсоол /БНБД 21.05.10/
- Газар шорооны ажил гүйцэтгэхэд /БНБД 3.02.01-90/

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Тайлбар
1.	Зөөврөөр далан байгуулах	м3	500	Талбайн ус зайлуулах схем зургийн дагуу өндөржилтийг хангаж гүйцэтгэх
2.	Битум цацлага хийх	м2	2292	Стандартын дагуу
3.	3 см зузаан дунд ширхэглэлтэй асфальтан хучлага	м3	68,7	Стандартын дагуу
4.	Өнгөт хавтангийн хайрган суурь байгуулах	м3	184	Стандартын дагуу
5.	Өнгөт хавтангаар явган зам, талбай хийх	м2	1896	Хавтангийн загварыг ажлын зургийн дагуу сонгож, захиалагчтай зөвшилцөн сонгох
6.	Авто замын хашлага тавих	м	470	Стандартын дагуу
7.	Явган хүний зам, талбайд хашлага тавих	м	340	Стандартын дагуу
8.	Цэцгийн мандал, явган хана өрөх /Өнгөлгөөний тоосго/	м3	19,1	Талбайн 2 талын явган хана бүхий цэцгийн мандал,
9.	Цэцгийн мандалд шороон дүүргэлт хийх	м3	300	Талбайн голын цэцгийн мандал Ф=5м
10.	Явган замын доогуур ус зайлуулах хоолой байрлуулах	у/м	2,2	Угсралтын ажлын явцад газар дээр өндөржилтийн хэмжилт хийсний үндсэн дээр гүйцэтгэх
11.	Авто замын тэмдэглэгээ хийх	у/м	359	Зурагт заасны дагуу
12.	Анхааруулах, мэдээлэх тэмдэг суурьлуулах	ш	12	Зурагт заасны дагуу
13.	Хар шороон дэвсгэр хийх	м2	840	Стандартын дагуу
14.	Зүлэг тарих	м2	840	Олон наст зүлэг
15.	Явган зам, талбайн гэрэлтүүлэг хийх/ ком/	ш	12	3,5-4 метр өндөр
16.	Гэрэлтүүлгийн утас татах	м	200	Техникийн нөхцлийг үндэслэн, Зурагт заасны дагуу
17.	Сандал	ш	6	Төмөр, ширэм хөлтэй, модон сандал
18.	Хогийн сав	ш	6	Сандалын загвартай уялдах
19.	Магадлашгүй ажлын зардал	төгрөг	2 644 023	Тухайн дүнгээр төсөвт тусгах
20.	Зураг, төсвийн үнэ	төгрөг	6 534 000	Тухайн дүнгээр төсөвт тусгах

Боловсруулсан: Хархорин сумын Архитектор:  Э.Очир-Эрдэнэ